



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/269

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "д", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Барилга, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2017"-д аймгаас төлөөлөгчдийг оролцуулах тухай Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газраас зөвлөгөөнд оролцсон төлөөлөгчид томилолтын зардлыг олгосугай.

2. Томилолтын зардлыг тооцон захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Э.Аззаяа/, Санхүү төрийн сангийн хэлтэс /Г.Сувд/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД